



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО**
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД

БАТЛАВ.

“.....” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

БАТЛАВ.

“.....” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

202.. оны ..-р сарын ...-ний өдөр

№....

Улаанбаатар хот

Энэхүү ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ /цаашид “гэрээ” гэх/-г

Нэг талаас: “.....” /РД:/, цаашид
“Худалдан авагч” гэх/, түүнийг төлөөлж Худалдан авах ажиллагаа хариуцсан
менежер;

Нөгөө талаас: “.....” /РД:/, цаашид “Худалдагч”,
хамтад нь “талууд” гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал нар
Иргэний хуулийн 243-261 дугаар зүйлийг үндэслэн, дараах харилцан тохиролцож
дор дурдсан нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1. Энэхүү Гэрээгээр Худалдагч нь Худалдан авагчийн хүсэл сонирхолд
нийцүүлэн

энэхүү гэрээний 2.1-т заасан барааг (цаашид “**Бараа эсхүл Гэрээт бараа**” гэх)-г
нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Худалдагч нь 202. оны дүгээр сарын ...-ний өдрөөс 202. оны дугаар
сарын-ны өдрийг хүртэл Худалдан авагчийн хүсэл сонирхолд бүрэн нийцсэн,
чанарын шаардлага хангасан Гэрээт барааг гэрээнд заасны дагуу Худалдан авагч
хүлээлгэн өгнө.

1.3. Худалдан авагч нь энэхүү Гэрээний 4 дүгээр зүйлд заасан нөхцөлөөр
Гэрээний төлбөрийг Худалдагчид шилжүүлнэ.

1.4. Гэрээний нэр томьёоны тайлбар: энэхүү гэрээнд дурдсан дараах нэр
томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1. “худалдсан эд хөрөнгийн биет байдлын доголдол” гэж Иргэний хуулийн
251 дүгээр зүйлийн 251.1 дэх хэсэгт заасныг;

1.4.2. худалдсан эд хөрөнгийн эрхийн доголдол” гэж Иргэний хуулийн 252
дугаар зүйлийн 252.1 дэх хэсэгт заасныг;

1.4.3. “ажил гүйцэтгэх боломжгүй болсон” гэж худалдагч байгууллага татан буугдсан, гэнэтийн эсхүл давагдашгүй хүчин зүйл бий болсон, гэрээг цаашид үргэлжлүүлэх боломжгүй нөхцөл байдлыг;

1.4.4. “гэрээний ноцтой зөрчил” гэж Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хориглосон үйлдэл гаргасан болон талуудын хууль ёсны ашиг сонирхолд ноцтой үр дагаврыг бий болгосон үйлдэл, эс үйлдлийг;

1.4.5. “гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл” гэж Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас баталсан “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл (Force majeure) болон Хүнд нөхцөл байдал “Hardship”-ыг гэрчлэх журам”-ын 1.2.1 дэх заалтад заасныг;

1.4.6. “хүнд нөхцөл байдал буюу Hardship” гэж Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас баталсан “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл (Force majeure) болон Хүнд нөхцөл байдал “Hardship”-ыг гэрчлэх журам”-ын 1.2.2 дахь заалтад заасныг тус тус ойлгоно.

1.5. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ талууд дараах зарчмыг дагаж мөрдөнө:

1.5.1. гэрээт барааг биет байдлын болон эрхийн доголдолгүй нийлүүлэх;

1.5.2. аливаа зохиогчийн эрхийн зөрчилгүй байх;

1.5.3. гэрээт ажлыг тохиролцсон хугацаанд хийж гүйцэтгэх;

1.5.4. үйлдвэрлэлийн осол гарахаас урьдчилан сэргийлэх.

ХОЁР.ГЭРЭЭТ БАРАА БОЛОН ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1.Худалдагч нь энэхүү Гэрээний 1.2-т заасан хугацааны дотор дор дурдсан гэрээт барааг чанар болон эрхийн доголдолгүй нийлүүлнэ.

2.2.Сайн чанарын материалаар Худалдан авагчийн хүсэл, сонирхолд бүрэн нийцсэн, чанарын доголдолгүй дараах барааг Худалдан авагчид нийлүүлнэ.

Нийлүүлэх барааны нэр	Тоо, ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
.....			
.....			
.....			
Нийт үнэ			

2.3.Худалдагч нь энэхүү гэрээний 2.2-т заасан барааг Худалдан авагчид нийлүүлэхээс өмнө 2 буюу түүнээс удаа Худалдан авагчид барааны шинж, чанар, хэлбэр дүрс болон бусад онцлогийн талаар танилцуулсан байна.

ГУРАВ. ГЭРЭЭТ БАРААГ НИЙЛҮҮЛЭХ, ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ

3.1.Худалдагч нь Гэрээт барааг нийлүүлэхдээ энэхүү Гэрээний 1.2-т заасан ерөнхий хугацааг баримтлах хэдий ч Худалдан авагч тусгайлан хугацаа заасан бол тухайн хугацаанд Гэрээт барааг нийлүүлнэ.

3.2.Худалдагч нь Худалдан авагчид Гэрээт барааны нийлүүлэлтийн явцын талаар тогтмол мэдээлж, энэ талаар тэмдэглэл үйлдэнэ.

3.3.Худалдан авагч нь Худалдагчийн шаардсанаар Гэрээт барааг нийлүүлэхэд шаардлагатай холбогдох мэдээ баримтыг цаг хугацаанд нь тодорхой, ойлгомжтой, шуурхай гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд өөрийн мэдээ, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна.

3.4.Худалдагч нь энэхүү Гэрээний 3.5-д заасны дагуу Гэрээт барааг эцсийн байдлаар Худалдан авагчид хүлээлгэн өгөх өдрөөс ажлын 10 хоногийн өмнө Худалдан авагчид эцсийн хувилбарыг танилцуулж, санал, зөвлөмжийг авна.

3.5.Худалдагч нь энэхүү Гэрээний 1.2-т заасан хугацааны дотор энэхүү Гэрээний 2 дугаар зүйлд заасан шаардлага хангасан Гэрээт барааг зохих ёсоор Худалдан авагчид хүлээлгэн өгнө.

3.6.Гэрээт барааг зохих ёсоор хүлээлгэн өгөх гэдэгт Гэрээт барааны шинж байдлаас хамааран Гэрээт барааны эхний загварыг хүлээлгэн өгөх, шаардлагатай зөвлөгөө туслалцааг үзүүлсэн байхыг ойлгоно.

3.7.Энэхүү Гэрээний 3.5-д заасны дагуу Худалдагчийн хүлээлгэн өгсөн Гэрээт бараа нь Гэрээнд заасан шаардлага хангаагүй бол Худалдан авагч нь Гэрээт барааг зохих ёсоор нийлүүлэх нэмэлт хугацаа тогтоож болно.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨР

4.1.Гэрээт барааны нийт төлбөр нь (..... хорин мянга) төгрөг байна. Энэхүү үнийн дүнд талууд Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) тооцсон болно.

4.2.Гэрээт барааны урьдчилгаа төлбөр нь нийт төлбөрийн 70% буюу (.....) төгрөг байх бөгөөд гэрээний урьдчилгаа төлбөрийг гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 3 хоногт багтаан худалдагчийн банкны тоот дансанд шилжүүлнэ.

4.3.Худалдан авагч нь энэхүү Гэрээний 3.5-д заасны дагуу Гэрээт барааг бүрэн хүлээн авсан бол ажлын 5 хоногт багтаан Гэрээт барааны үлдэгдэл төлбөр 30% буюу (.....) төгрөгийг худалдагчийн банкны тоот дансанд шилжүүлнэ.

4.4.Худалдагчийн хүлээлгэн өгсөн Гэрээт бараанд энэхүү Гэрээний 3.7-д заасны дагуу засвар оруулах, эсхүл биет байдлын доголдолгүй ижил төрлийн бараагаар сольж өгөх шаардлага үүссэн тохиолдолд Худалдан авагч нь тэр хугацаагаар үлдэгдэл төлбөрийг шилжүүлэхгүй байж болно.

4.5.Худалдагч нь гэрээнд заасан үндсэн хугацаа болон Худалдан авагчийн олгосон нэмэлт хугацаанд гэрээт барааг нийлүүлээгүй тохиолдолд Худалдан авагч нь гэрээт барааны төлбөрийг төлөхгүй.

4.6.Гэрээт барааны явцад эсхүл барааг хүлээн авсны дараагаар гэрээнд тусгагдаагүй нэмэлт нийлүүлэлт хийх шаардлагатай болсон тохиолдолд талууд харилцан тохиролцож хавсралт үйлдэн нэмэлт төлбөрөөр барааг нийлүүлнэ.

ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1.Худалдан авагч дараах эрхтэй:

5.1.1.тогтоосон хугацаанд дахин засварлалт хийх эсхүл биет байдлын доголдолгүй ижил төрлийн бараагаар сольж өгөхийг худалдагчаас шаардах;

5.1.2.энэхүү гэрээний 5.1.1-д заасны дагуу шаардлага хүргүүлсэн хэдий ч худалдагч шаардлагыг биелүүлэхээс татгалзсан эсхүл дахин нийлүүлсэн бараа нь шаардлага хангахгүй бол гэрээнээс татгалзаж, учирсан хохирлоо шаардах;

5.1.3.Худалдагчтай тохиролцсон барааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг худалдагчаас авч танилцах;

5.1.4.барааны биет байдлын доголдолтой эсэхийг шалгах зорилгоор бараа хүлээн авах үед мэргэжлийн шинжээч ажиллуулах;

5.1.5.ажлын үр дүнг хүлээж авснаас хойш хүлээн авах үед илрүүлэх боломжгүй доголдлын тухай гэрээний хугацаанд гомдлын шаардлага гаргах;

5.1.6.Худалдагч сануулсан доголдлыг 4 (дөрөв) буюу түүнээс дээш удаа засаж сайжруулаагүй, гэрээт ажлыг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон, эсхүл гэрээний ноцтой зөрчил гаргасан бол гэрээг цуцлах, учирсан хохирлоо шаардах.

5.2.Худалдан авагч дараах үүрэгтэй:

5.2.1.гэрээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд Худалдагчид шилжүүлэх;

5.2.2.гэрээгээр тохирсон бараатай танилцаж, түүнийг биет байдлын болон эрхийн доголдолтой эсэхийг шалгаж авах;

5.2.3.гэрээгээр тохирсон барааны онцлог шинж, захиалгын талаарх мэдээллийг цаг тухай бүрт гаргаж өгөх;

5.2.4.гэрээгээр тохирсон барааг хүлээн авах газар, он, сар, өдөр болон бусад шаардлагатай мэдээллийг Худалдагчид өгөх.

5.3.Худалдагч дараах эрхтэй:

5.3.1.энэхүү гэрээнд заасны дагуу Худалдан авагчийн санал, зөвлөмжийг авахаар ажлын явцыг тухай бүр танилцуулж байсан хэдий ч Худалдан авагч өөрийн санал, зөвлөмжийг илэрхийлж байгаагүй бол чанарын өндөр түвшинд өөрийн санаачлагаар Гэрээт барааг нийлүүлэх;

5.3.2.Гэрээгээр тохирсон төлбөрийг шилжүүлэхийг Худалдан авагчаас шаардах;

5.3.3.Худалдан авагч барааны шинж чанарт өөрчлөлт оруулах эсэхийг бичгээр лавлан, хуанлийн 3 хоногийн дотор саналаа ирүүлэхийг шаардах.

5.4.Худалдагч дараах үүрэгтэй:

5.4.1.гэрээнд заасан ажил үүргийг гүйцэтгэхдээ 1.5-д заасан зарчмуудыг баримталж гүйцэтгэх;

5.4.2.гэрээт ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх буюу гэрээт барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх;

5.4.3.Худалдан авагч шаардсанаар ажлын болон барааны доголдлыг арилгах;

5.4.4.ажлын үр дүн болон барааны чанарын доголдлыг арилгах зардлыг хариуцах;

5.4.5.гэрээт бараа, ажлын үр дүнг Худалдан авагчтай тохирсон хугацаанд хүлээлцэх;

5.4.6.ажлын үр дүн, барааны чанарт муугаар нөлөөлөх нөхцөл байдлын талаар Худалдан авагчид нэн даруй мэдэгдэх;

5.5.Нууцлал: Талууд гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон харилцан солилцсон мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг гэрээ байгуулснаас хойш хугацаагүйгээр чанд хадгална.

5.6.Үнэн зөв мэдээлэл: Гэрээний үүргийн дагуу талуудаас нөгөө талдаа гаргаж өгч буй баримт бичиг болон мэдээлэл нь үнэн зөв болно.

5.7.Эрх үүрэг шилжүүлээгүй байх: Худалдагч тал нь гэрээ байгуулсан өдрөөс эхлэн энэхүү гэрээгээр хүлээсэн эрх үүргээ бүрэн болон хэсэгчилсэн байдлаар, бусад ямар ч нөхцөлөөр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

5.8.Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш Худалдагчийн зүгээс Гэрээг цуцлах эрхгүй бөгөөд Худалдагчийн буруугаас Гэрээ дуусгавар болох тохиолдолд Гэрээт барааны төлбөрийн 30%-тай тэнцэхүйц торгууль төлнө.

5.9.Оюуны өмч: Талуудаас гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ашигласан мэдээлэл, баримт материал, оюуны өмч барааны тэмдэгт, хамааралтай мэдээлэл, санхүүгийн болон бизнесийн баримт бичгүүд нь тухайн талын өмчлөл, эзэмшилд хуулийн дагуу хэвээр хадгалагдана. Энэхүү гэрээний дүнд бий болсон аливаа мэдээлэл, оюуны өмч барааны тэмдэгт зэрэг нь Худалдан авагчийн өмч байна.

5.10.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлсийн улмаас биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд талуудын эрх, үүрэг хэвээр хадгалагдаж, давагдашгүй хүчин зүйл өнгөрсөн хугацаанаас эхлэн Гэрээний нөхцөл хэвээр үргэлжилнэ.

ЗУРГАА.ХАРИУЦЛАГА

6.1.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл хангалтгүй биелүүлснээс нөгөө талд учирсан хохирлыг буруутай тал нь бүрэн хариуцаж хохиролгүй болгох ба хуульд заасан хариуцлага хүлээнэ.

6.2.Худалдагч нь чанарын шаардлага хангаагүй Гэрээт барааг нийлүүлсний улмаас Гэрээт бараанд засвар оруулах, эсхүл сольж өгөх шаардлагатай болсон бол Худалдагч өөрийн зардлаар нийлүүлнэ.

6.3.Худалдагч нь Гэрээт барааг засварлах, эсхүл сольж өгөхөөс татгалзсан тохиолдолд Худалдан авагч нь Гэрээний төлбөрийг шилжүүлэхээс татгалзах эрхтэй.

6.4.Худалдан авагч нь Гэрээт барааны төлбөрийг энэхүү гэрээнд заасан хугацаанд шилжүүлээгүй тохиолдолд хоног тутам 0.1% алданги төлнө.

ДОЛОО.ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

7.1.Талуудын хүлээсэн үүрэг хариуцлагын дагуу урьдчилан харж зохицуулагдах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдалд аль аль тал нь ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

7.2.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдал арилмагц талууд гэрээний үүргээ биелүүлэх үүрэгтэй.

7.3.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл нь үүрэг гүйцэтгэх хугацаа хойшлогдох, хохирол, гэрээний хариуцлагаас чөлөөлөх бөгөөд гэрээний үндсэн үүргээс чөлөөлөхгүй.

7.4.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын гэрчилгээгээр нотолно.

НАЙМ.ТАЛУУДЫН ХАРИЛЦАХ АЛБАН ЁСНЫ ХАЯГ

8.1.Талууд гэрээтэй холбоотойгоор харилцахдаа энэхүү зүйлд заасан хаяг мэдээллийг үндэслэнэ.

8.2. Худалдан авагч талын мэдээлэл

8.2.1.Утас:

8.2.2.Цахим шуудан:

8.3.Худалдагч талын мэдээлэл

8.3.1.Утас:

8.3.2.Цахим шуудан:

8.4.Хэрэв талуудын аль нэг нь гэрээний 8.2, 8.3 дахь хэсэгт заасан мэдээлэлдээ өөрчлөлт оруулах бол нөгөө талдаа ажлын 5 хоногийн дотор аливаа хэлбэрээр мэдэгдэж баталгаажуулна. Ийнхүү мэдээлээгүйгээс үүссэн аливаа хохирол, зардлыг мэдэгдээгүй тал нь бүрэн хариуцна.

ЕС.БУСАД

9.1.Гэрээ хүчин төгөлдөр болох:

Талууд нь гарын үсгээ зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно. Энэ гэрээг Монгол хэлээр хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчин чадалтай байна.

9.2.Нэмэлт өөрчлөлт:

Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцох бөгөөд зөвхөн бичгээр (хавсралт) оруулсан нэмэлт өөрчлөлт нь Гэрээний салшгүй хэсэг байна.

9.3.Санал хүсэлт: Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, гэрээг дуусгавар болгох хугацаанаас нь өмнө цуцлах мэдэгдэл болон гэрээтэй холбоотой аль нэг талаас нөгөө талдаа гаргаж буй аливаа санал, санаачлага, мэдэгдэл хүсэлтийг зөвхөн бичгээр (хавсралт) баталгаажуулна.

9.4.Талууд гэрээтэй холбогдон гарсан аливаа асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрэхгүй бол Монгол Улсын шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

9.5.Дараах баримт бичиг нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна. Үүнд:

- 9.5.1. Худалдан авагч болон худалдагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 9.5.2. Худалдагчийн барааны тодорхойлолт, танилцуулга, мэдээлэл;
- 9.5.3. Худалдан авагчаас баталсан барааны загвар, дизайн, тоо, хэмжээ болон холбогдох бусад мэдээллийг агуулсан ажлын даалгавар.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Худалдан авагч:
“.....” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

Худалдагч:
“.....” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

Хаяг:
Улаанбаатар хот, дүүрэг,
..... дугаар хороолол,-р
байр, тоот.
Цахим шуудан:
Утас:

Хаяг:
Улаанбаатар хот, дүүрэг,
..... дугаар хороолол,-р
байр, тоот.
Цахим шуудан:
Утас:

